



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/419

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн бүтээн байгуулалт, соёл урлагийн үйл ажиллагааг сурталчлах зорилтын хүрээнд “Тэмээний өв соёлыг сурталчлах зөвлөгөөн болоод ашиг шим үр дүнгийн тухай”, “Ховд хотын 340 жилийн ойн тэмдэглэлт үйл ажиллагааг сурталчлах” олон нийтэд түгээх зардалд 2,500,000 төгрөгийг баталж зарцуулсугай.

2. Дээрх зардалд зарцуулагдах 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8409001 1243

Zah A/419 Och